# МОНГОЛ УЛС
# ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 05 өдөр Дугаар А/211 Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шинэчлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7, 21 дүгээр зүйлийн 21.3.2, 28.1.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IX хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мөрөн сумын Засаг даргын ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн инженерийн шугам сүлжээтэй бүс тэлсэнтэй холбоотой тухайн бүсэд газраа зориулалтын дагуу эзэмшиж байгаа 2 иргэний нийт 1.5032га (15032м2) газрын гэрчилгээг шинэчлэн өмнө олгогдсон шийдвэрийн газар эзэмших хугацаанаас эзэмшсэн хугацааг хасаж тооцон эзэмшүүлсүгэй.

2.Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3.Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН



671?010078

Аймгийн Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 05 -ны өдрийн
А/211 дугээр захирамжийн хавсралт

## ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭ ШИНЭЧЛЭХ ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

| № | Газар эзэмшигч этгээдийн овог, нэр, регистр | Нэгж талбарын дугаар | Газрын талбайн хэмжээ м² | Газрын зориулалт, нэгдмэл сангийн ангиллын код | | Газрын байршил, хаяг | | Эрхийн төрөл | Газар эзэмшүүлэх үлдсэн хугацаа | Хүчингүй болгож буй шийдвэрийн огноо, дугаар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хархүүний булаг Лувсанжамц Цэрэндулам РЭ52070561 | 6712010658 | 10045 | Үйлдвэрлэл | 2302 | 13-р баг | РӨНС-ын зүүн талд | эзэмшил | 5 | Мөрөн сумын Засаг даргын 2013.05.22-ны өдрийн А/115 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх заалт |
| 2 | Хархүүний булаг Лувсанжамц Цэрэндулам РЭ52070561 | 6712013500 | 4987 | Үйлдвэрлэл | 2302 | 13-р баг | РӨНС-ын зүүн талд | эзэмшил | 5 | Мөрөн сумын Засаг даргын 2013.05.22-ны өдрийн А/115 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь заалт |

Нийт газрын хэмжээ: 15032м²

------------oOo------------